

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГААС  
“ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН ТОГТОЛЦОО”  
ЦАХИМ СИСТЕМД МЭДЭЭЛЭЛ, ЗАСВАР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2025 оны 10 дугаар сарын 28

Улаанбаатар хот

Монгол Улсын Үндэсний номын сангийн “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд ажил эрхлэлийн түүхтэй холбоотой алдаатай бүртгэлүүд байгаагүй.

“Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд дараах засвар, шинэчлэлийг хийсэн болно. Үүнд:

1. Албан тушаалын төрөл алдаатай бүртгэгдсэн 33 албан хаагчийн мэдээллийг Засгийн газрын 2024 оны 240 дугаар тогтоолын дагуу засварлан шинэчилсэн.
2. Боловсролын түвшин мэдээлэл дутуу 26 албан хаагчийн 3 нь төслийн албан хаагч байсныг системээс хасч, бусад 23 албан хаагчийн мэдээллийг шинэчлэн бүртгэсэн.
3. Төрийн албаны ангилал, албан тушаалын ангилал, албан тушаалын дэд ангилал, төрийн албаны зэрэглэл, цалингийн сүлжээ, шатлал зэрэг талбар үзүүлэлтүүд нь дутуу бүртгэсэн 9 албан хаагч нь Төвөд номыг дижиталчлах төслийн (ACIP) албан хаагчид бөгөөд цалинг төслийн зүгээс санхүүжүүлдэг ба төрийн албаны ангиллаар цалинждаггүй. ХНУМТ цахим систем дээрх бүртгэлээс албан хэрэгцээнд /ээлжийн амралт, ажилласан жил, холбоо барих зэрэг/ мэдээллийг ашигладаг байсан талаарх тайлбар мэдээллийг 2025 оны 03-р сарын 12-ны өдөр Төрийн албаны зөвлөлийн референт Л.Лхамжав-д [lkhamjav@csc.gov.mn](mailto:lkhamjav@csc.gov.mn) хаягаар хүргүүлж байсан. Мөн 2025 оны 10-р сарын 09-ний өдөр ТАЗ-ийн Сургалт, судалгаа мэдээллийн нэгдсэн төвийн референт Э.Энхзаяатай /85004464/ холбогдон дээрх мэдээллийг өгч, зөвлөгөө авсан ба төслийн 9 албан хаагчийг тус системээс хассан болно.
4. “Төрийн албан хаагчийн портал”-аар төрийн албан хаагчийн анкетыг албан хаагчдаар өөрөөр нь баталгаажуулах ажлыг хангуулахаар зохион байгуулж ажиллаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 38 албан хаагч өөрийн мэдээллээ баталгаажуулаад байна.

Чиглэлийн дагуу албан хаагчдын мэдээллийн үнэн зөв байдлыг хангахад анхаарч, зарим албан хаагчдын мэдээллийг хувийн хэргээс нь өөрөө оруулах зэргээр ажиллаж байна.

МУҮНС, Хүний нөөцийн ажилтан

Д.Мөнхгэрэл

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГААС  
“ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН ТОГТОЛЦОО”  
ЦАХИМ СИСТЕМД МЭДЭЭЛЭЛ, ЗАСВАР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Монгол Улсын Үндэсний номын сангийн “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд ажил эрхлэлийн түүхтэй холбоотой алдаатай бүртгэлүүд байгаагүй.

“Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд “Төрийн албан хаагчийн портал”-аар төрийн албан хаагчийн анкетыг албан хаагчдаар өөрөөр нь баталгаажуулах ажлыг зохион байгуулж, албан хаагчдын мэдээллийн үнэн зөв байдлыг хангахад анхаарч, зарим албан хаагчдын мэдээллийг хувийн хэргээс нь өөрөө оруулах зэргээр ажиллаж 100% буюу нийт 110 албан хаагч өөрийн мэдээллээ баталгаажуулсан байна.

МУҮНС, Хүний нөөцийн ажилтан

Д.Мөнхгэрэл